	8.Өр авлага үүсгэхгүй, хэрэв үүсвэл богино хугацаанд барагдуулж ажиллахад хяналт тавих;	Өглөг, авлагагүй хяналт тавьж ажилласан байна.	Г, Х
	9.Зохицуулалтын үйлчилгээний хөлс, тэмдэгтийн хураамж, торгуулийн орлогыг бүртгэх, тайлагнахад хяналт тавьж ажиллах;	Зохицуулалт үйлчилгээний орлогыг үнэн зөв бүртгэж тайлагнасан байна.	Г, Х
	10.Ажилтан албан хаагчдын томилолтын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, томилолтын илүү дутуу тооцоог хийх, зардлыг үнэн зөв тайлагнаж бүртгэх, томилолтын төсөв, томилолтын хуудас, тайлан, бусад шаардагдах баримтуудыг зохих журмын дагуу архивлах, тайлагнахад хяналт тавьж ажиллах;	Хяналт тавьж, санхүүгийн баримт архивлагдсан байна.	Г, Х

4 дүгээр зорилтын хүрээнд	1.Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг үнэн зөв гаргаж Сангийн яаманд хуульд заасан хугацаанд нэгтгүүлэх, хяналт тавих;	Тайлан мэдээг үнэн зөв, хугацаанд тайлагнаж, удирдлагуудыг мэдээллээр хангаж, хөрөнгөтэй холбоотой шийдвэрүүд гарч тайлан бүртгэлд тусгасан байна.	Г, Х
	2.Төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг улирал тутам удирдлагуудад танилцуулах;	Цаг хугацаанд нь тоо мэдээг танилцуулсан байна.	Г, Х
	3.Хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлэх, Э-тайланд шивэх, хяналт тавих;	Хуулийн хугацаанд тайлагнасан байна.	Г, Х
	4.Жилийн эцсийн Аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэх, Э-тайланд шивэх, хяналт тавих;	Тайлан баталгаажиж шивэгдсэн байна.	Г, Х
	5.Ажил олгогч болон ажиллагсдаас суутгасан Нийгмийн даатгалын шимтгэлийг зөв тооцож, цахимаар болон цаасаар хүргэх, хагас жил бүтэн жилийн эцэст тооцоо нийлж, актаар баримтжуулах ажилд хяналт тавих;	Хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнасан байна.	Г, Х
	6.Улирал бүрийн эцэст ХАОАТ-ын тайланг гаргаж, харьяа татварын байгууллагад тайлагнах ажилд хяналт тавих;	Хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнасан байна.	Г, Х
	7.Цалинг сард 2 удаа тавьж, тэтгэвэр тэтгэмж, ээлжийн амралтын тооцоо, гадаад дотоодын томилолт зэрэг зардлын төсвийг батлуулан зохих журмаар бодож тухай бүр олгох ажилд хяналт тавих;	Хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнасан байна.	Г, Х
	8.Өмч, хөрөнгийн хадгалалт хамгаалалтад бүртгэлээр хяналт тавьж, ашиглалтын чанарыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих;	Хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнасан байна.	Г, Х
	9.Хорооны Өмч хамгааллын байнгын зөвлөлийн ажилд дэмжлэг үзүүлэх, хөрөнгө, техник	Хяналт тавьж зохих шийдвэрийг гаргуулсан	

МОНГОЛ УЛС ЗӨВЛӨХӨӨРӨӨ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

	хэрэгслийн элэгдэл, дахин үнэлгээ, өртөг зардлын тооцоо хийх, устгах, актлах хөрөнгийн асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллах;	байна.	
	10.Бэлэн ба бэлэн бус гүйлгээний анхан шатны баримтыг үнэн зөв, хучин төгөлдөр баримтаар бүрдүүлэхэд хяналт тавьж ажиллах;	Хяналт тавьж үнэн зөв тайлагнасан байна.	Г, Х
	11.Анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийн данс, санхүүгийн тайлан, тооллого тооцооны бүх баримтыг төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу хөтөлж, эмхлэн цэгцэлж, бүрэн гүйцэд бүртгэлтэйгээр архивд шилжүүлэх;	Санхүүгийн баримт архивлагдсан байна.	Г, Х
5 дугаар зорилтын хүрээнд	1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх ажлыг удирдан зохион байгуулах;	Санхүү төсөвтэй холбоотой холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Г, Х
6 дугаар зорилтын хүрээнд	1.Аудитын байгууллагаас санхүүгийн нэгдсэн тайланд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагад хариу тайлбар хүргүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	2.Дотоод хяналтын хэлтсээс төлөвлөгөөт болон явцын шалгалтаар илрүүлсэн санхүүгийн зөрчлийг арилгах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах ажлыг удирдан зохион байгуулах;	Дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	3.Хорооны удирдлага, гишүүд, Хяналтын зөвлөлийн гишүүд, Ажлын алба, хэлтсийн удирдлагыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хариуцсан чиглэлээрээ мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлж, үнэн зөв	Мэргэшил, арга зүйгээр тухай бүр хангаж ажилласан байна.	Г, Х

	мэдээллээр хангах, тайлагнах;		
	4.Хорооны худалдан авах ажиллагааг төлөвлөх, түүний хэрэгжилтэд хяналт тавих;	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	5.Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг ил тод болгох ажилд хяналт тавих;	Ил тод, мэдээллээр хангаж ажилласан байна.	Г, Х
	6.Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, үр дүнг тайлагнах, хагас, бүтэн жилийн тайлан хүргүүлэх ажилд хяналт тавих.	Тайлан хугацаандаа нэгтгэгдэж, дүгнэгдсэн байна.	Г, Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	- нягтлан бодох бүртгэл /041101/; - эдийн засагч /031101/; - санхүү /041201/.	
Мэргэшил	Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд 12-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ, судалгаа хийх ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийн ханган тайлагнах, хяналт тавих; - хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; - албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах; - ажлын гүйцэтгэл, үр дүнг хариуцаж, үүрэг хариуцлага хүлээх чадвартай байх; - эрсдэлийг урьдчилан тооцох, гарах арга замыг тодорхойлох чадвартай байх; - бусад.
	Дүн шинжилгээ хийх	- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж дүгнэлт гаргах; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах, дүгнэлт гаргах;

		- судалгааны арга зүйн мэдлэгтэй, хэрэгжүүлэх чадвартай байх. - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - хуульд нийцсэн оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - шийдвэрийн үр дагаврыг урьдчилан тооцоолох; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - бусад.
	Манлайлах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - ёс зүй, хувийн зохион байгуулалтын хувьд хамт олноо манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх; - бусад.
	Бусад	- монгол хэлний ярианы болон бичгийн өндөр ур чадвартай байх; - албан хэрэг хөтлөх ур чадвар сайтай, эмх цэгцтэй байх; - англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын өргөн хэрэглээний программ болон тооцооллын программыг эзэмшсэн байх; - удирдах түвшинд багаар хамтарч ажиллах; - төрийн болон албаны нууцыг хадгалах; - илүү цагаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

<u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u>

Захиргаа удирдлагын газрын дарга.

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект</u>
Тооцооны нягтлан бодогч-2 Нярав-1 Жолооч-4	1.Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, албан хаагч 2.Төрийн албаны зөвлөлийн Салбар

ЗӨВШӨӨРӨГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Нийт: 7	зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга; 3.Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн холбогдох албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА ..... /Э. Эрхамбаяр/ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20..... оны ..... дугаар сарын ..... -ны өдөр	Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 20 05 13 Дугаар: 189

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Шийдвэрийн огноо: 2020. 5. 25

Дугаар: Б/127

(тамга/тэмдэг)

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА ..... /Т.ЖАМБААЖАМЦ/

(Гарын үсэг) (Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)

2020 оны 5 дугаар сарын 21 -ны өдөр

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРӨВ

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга
2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн Б/127
дугаартушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

○ [√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан.

[ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг батлагдсан огноо:

Байгууллагын нэр:

○ Санхүүгийн зохицуулах хороо

Нэгжийн нэр:

Захиргаа удирдлагын газар

Албан тушаалын нэр:

Санхүү, хөрөнгө оруулалтын албаны тооцооны нягтлан бодогч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Мэргэжлийн албан хаагч, ТҮ-7

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

○ "Төсвийн тухай хууль", "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийг дагаж мөрдөх, холбогдох бусад хуулиудыг хэрэгжүүлэх, үл хөдлөх хөрөнгийн ашиглалт хамгаалалт, бүртгэлийн ажлыг гүйцэтгэх, гадаад дотоод хэрэглэгчийг мэдээллээр хангах, нярвын ажилд дэмжлэг үзүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журмыг баримтлан батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, тайлагнах.

Албан тушаалын зорилт:

1.Хорооны төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж хянуулах.

2.Хорооны үндсэн хөрөнгийн хангалт, бүртгэлээр хяналт тавьж ажиллах.

3.Хорооны нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтөлж, санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн мэдээ, мэдээллийг бэлдэх, зохицуулалт үйлчилгээний орлого, торгуулийн орлого, тэмдэгтийн хураамжийн орлогуудыг бүртгэх, тайлагнах, холбогдох өглөг, авлагын тооцооллыг хийх, өглөг авлагыг барагдуулах, тооцоо нийлж баталгаажуулах.

4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журмыг баримтлан батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, тайлагнах, мэдээлэх.

5.Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах.

6.Томилолт, бараа материал, жолооч нарын шатахууны тооцоог бодож тайлан бүртгэлд тусгах, анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавих, нярвын тооцоог бодох.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Анхан шатны баримтуудыг хянаж, шалган санхүүгийн ажил гүйлгээг баримтжуулах ажлыг хийж гүйцэтгэх;	Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
	2.Хороонд олон улсын болон гадаад орны зээл тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, санхүүжилт зориулалтын дагуу зарцуулахад анхаарч ажиллах;	Хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г
	3.Төсвийн зардлыг ангилал, бүлгийн дагуу зүй зохистой захиран зарцуулж, зарцуулалтын мэдээ тайланг цаг хугацаанд нь тайлагнах, холбогдох газар хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэх;	Мэдээ тайланг үнэн зөв гаргасан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Үндсэн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээг программд зөв алдаагүй хийж, нярвын тайлангийн үлдэгдэлтэй тулган шалгаж, нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг хийж гүйцэтгэх;	Хорооны үндсэн хөрөнгийн ашиглалт, бүртгэл, холбогдох хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х

	2.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн журмыг дагаж мөрдөх, шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хийж гүйцэтгэх;	Журмын хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г
	3.Хорооны үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг үнэн зөв алдаагүй тооцож, нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг хийж гүйцэтгэх;	Бүртгэлийг үнэн зөв хөтөлсөн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Хорооны нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтөлж, санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн мэдээ, мэдээллийг үнэн зөв гаргаж тайлагнах;	НББ-ийн хуулийн хэрэгжилт хангагдан, тайлан мэдээ цаг хугацаандаа гарсан байна.	Г
	2.Санхүүгийн баримт болон хариуцсан ажлын бичиг баримтыг Архивын тухай хуулийн дагуу боловсруулж, архивд хүлээлгэн өгөх ажлыг хийж гүйцэтгэх;	Баримт бичгийг архивд хүлээлгэн өгсөн байна.	Г
	3.Зохицуулалт үйлчилгээний хөлс, торгуулийн орлого, тэмдэгтийн хураамжийн орлогыг бүртгэн авч, тайлагнах;	Бүртгэлийг үнэн зөвөөр тайлагнасан байх.	Г
	4.Холбогдох өглөг, авлагын тооцоог хийх, хяналт тавьж барагдуулах;	Өглөг, авлагын тооцоо хийгдсэн байх.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Хорооны дараа жилийн төсвийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулж, саналаа Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэх;	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, хугацаанд төсөв төлөвлөгөөг батлуулж, ил тод нээлттэй явуулах, төсвийн дүн шинжилгээ, судалгааг хийх, тайланг хүргүүлсэн байна.	Г
	2.Хорооны худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулж, баталгаажуулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэх;	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, хугацаанд төсөв төлөвлөгөөг батлуулж, ил тод нээлттэй явуулах, төсвийн дүн шинжилгээ, судалгааг хийх, тайланг хүргүүлсэн байна.	Г

	3.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт орсон үед өөрчлөлтийг Хорооны даргын тушаалаар батлуулж, Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт "Төрийн өмчийн худалдан авах ажиллагаа"-ны цахим системээр дамжуулан бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэх;	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, хугацаанд төсөв төлөвлөгөөг батлуулж, ил тод нээлттэй явуулах, төсвийн дүн шинжилгээ, судалгааг хийх, тайланг хүргүүлсэн байна.	Г
	4.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу үнэлгээний хороо байгуулах ажлыг зохион байгуулж, хийж гүйцэтгэх;	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, хугацаанд төсөв төлөвлөгөөг батлуулж, ил тод нээлттэй явуулах, төсвийн дүн шинжилгээ, судалгааг хийх, тайланг хүргүүлсэн байна.	Г
	5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журмын дагуу явуулах ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль, дүрэм журмын дагуу явуулах ажлыг зохион байгуулсан байна.	Г
	6.Захиалагч болон Үнэлгээний хороог холбогдох мэдээллээр хангах худалдан авах ажиллагааг зохион байгуулах;	Холбогдох мэдээллээр ханган ажилласан байна.	Г
	7.Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг ил тод болгох, цахим системд оруулах, самбарт байршуулж хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан гүйцэтгэх;	Хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г
	8.Худалдан авах ажиллагааны баримт материалыг жил бүр архивд хүлээлгэн өгөх ажлыг хийж гүйцэтгэх;	Худалдан авах ажиллагааны баримт материалыг архивд хүлээлгэн өгсөн байна.	Г
	9.Худалдан авах ажиллагааны тайланг хуульд заасан хугацаанд тайлагнан удирдлагаар хянуулж Сангийн яаманд хагас, бүтэн жилийн тайланг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэх;	Тайлан мэдээг хүргүүлэн ажилласан байна.	Г

5 дугаар зорилтын хүрээнд	1.Шинэ гарсан хууль тогтоомж, шийдвэрүүдийг тухай бүр судалж, ажлын байранд мөрдлөг болгох ажлыг хийж гүйцэтгэх;	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан байна.	Г
	2.Хорооны шийдвэр, Хорооны удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хугацаанд нь, чанартай гүйцэтгэх;	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг чанартай гүйцэтгэсэн байна.	Г
	3.Хорооноос зохион байгуулж байгаа олон нийтийн арга хэмжээнд оролцох;	Олон нийтийн арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцсон байна.	Г
	4.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг хангаж ажиллах;	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
	5.Аудитын газар болон Хорооны Дотоод хяналтын хэлтсээс илрүүлсэн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэх;	Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэх байна.	Г
6 дугаар зорилтын хүрээнд	1.Жолооч нарын шатахууны тооцоо, шатахууны олголт зарцуулалтад хяналт тавьж ажиллах;	Шатахууны зарцуулалтад хяналт тавин ажилласан байна.	Г
	2.Няравын бараа материалын орлого, зарлагад хяналт тавих, тайланг Санхүүгийн программд гүйлгээг хийх;	Хяналт тавин ажилласан байна.	Г, Х
	3.Томилолтын бодит тооцоог хийн, хяналт тавьж ажиллах.	Хяналт тавин ажилласан байна.	Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
Мэргэжил	- нягтлан бодох бүртгэл; - санхүү; - эдийн засаг.
Мэргэшил	
Туршлага	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх.

Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - албан үүргээ хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; - албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - ажилдаа бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт сайтай байх; - ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; - иргэнтэй хүндэтгэлтэй, соёлтой харилцах; - бусад.
	Бусад	- монгол хэлний ярианы болон бичгийн ур чадвартай байх; - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах ур чадвар сайтай, эмх цэгцтэй байх; - өөрийн мэдлэг, ур чадварыг бүрэн дайчлах, бусдын санал, бодлыг сонсох; - багаар ажиллах чадвартай байх; - англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын өргөн хэрэглээний программ болон тооцооллын программыг эзэмшсэн байх; - төрийн болон албаны нууцыг хадгалах; - илүү цагаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект
	1.Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, албан хаагч; 2.Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга; 3.Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн холбогдох албан

	тушаалтан, иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

Э. ..... Э. .....

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20..... оны ..... дугаар сарын ..... -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: .....

(тамга/тэмдэг)

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА ..... Л. /ЛЭЖАМБААЖАМЦ/

(Гарын үсэг) (Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын
2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 5/127
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

[√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан.

[ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг батлагдсан огноо:

Байгууллагын нэр: Санхүүгийн зохицуулах хороо

Нэгжийн нэр: Захиргаа удирдлагын газар

Албан тушаалын нэр: Санхүү, хөрөнгө оруулалтын албаны тооцооны нягтлан бодогч

Албан тушаалын ангилал, зэрэглэл: Мэргэжлийн албан хаагч, ТҮ-7

Ажлын цаг: Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил: Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр

Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн

Онцгой нөхцөл: Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлж, нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандарт, заавар журмын дагуу үнэн зөв хөтөлж, мэдээ тайланг хуулийн хугацаанд гаргах.

Албан тушаалын зорилт:

1.Нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандарт, заавар журмын дагуу үнэн зөв хөтөлж, мэдээ тайланг хуулийн хугацаанд гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх, Олон улсын гишүүнчлэлийн байгууллагын хураамжийг шилжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэх.

2.Цалин хөлсний бүртгэл, Нийгмийн даатгал, Хувь хүний орлогын албан татварын болон холбогдох тооцоог хуулийн дагуу тооцож, олгох, мэдээ тайланг хуулийн хугацаанд тайлагнах ажлыг хийж гүйцэтгэх.

3.Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж төсвийн санхүүжилтийн мэдээ мэдээллийг гаргаж цахим хуудас болон хорооны самбарт байршуулах ажлыг хариуцан гүйцэтгэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандарт, заавар журмын дагуу ажилчдын цалин, нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татварын тайланг үнэн зөв хөтөлж, мэдээ тайланг хуулийн хугацаанд гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх;	Нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандарт, заавар журмын дагуу ажилчдын цалин, нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татварын тайланг үнэн зөв хөтөлж, мэдээ тайланг хуулийн хугацаанд гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	Г
	2.Олон улсын байгууллагуудын нэхэмжлэх, гадаад гуйвуулгын маягтуудыг бэлтгэн хураамжийн төлбөр төлөх ажлуудыг хийж гүйцэтгэх;	Нэхэмжлэхийн дагуу төлбөр, хураамжийг шилжүүлсэн ажилласан байна.	Г
	3.Санхүүгийн анхан шатны баримт бичгүүдийн бүрдлийг хянаж шалгах, архивын стандарт, заавар журмын дагуу үдэж архивын ажилтанд хүлээлгэн өгөх ажлыг хийж гүйцэтгэх;	Баримт бичгийг стандартын дагуу архивд хүлээлгэн өгсөн байна.	Г

2 дугаар зорилтын хүрээнд	1.Хорооны төсвийн төсөлд цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, улсын байцаагчдын урамшуулал зэрэг зардлуудыг үнэн зөв тооцоолж зардлын төсөвт суулгуулах ажлыг хийж гүйцэтгэх;	Зардал, урамшууллыг үнэн зөв тооцоолж, төсөвт суулгуулан ажилласан байна.	Г
	2.Хорооны ажилчдын цалинг сард 2 удаа, тэтгэвэр тэтгэмж, ээлжийн амралтын тооцоо, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, улсын байцаагчийн урамшуулал, нэмэгдэл урамшуулал зэргийг зохих журмаар бодож тухай бүр хугацаанд нь олгох;	Цалин урамшууллыг зохих журмын дагуу бодож, хугацаанд нь олгосон байна.	Г
	3.Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг сар бүр тооцож цахимаар болон цаасаар баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэх;	Баталгаажуулалт хийгдсэн байна.	Г
	4.Хувь хүний орлогын албан татварын тайланг гаргаж улирал бүр Татварын хэлтэст илгээн баталгаажуулж, тооцоо нийлэх ажлыг хийж гүйцэтгэх;	Тооцоо нийлсэн байна.	Г
	5.Ажилтан албан хаагчдын нийгмийн даатгалын болон татвар төлөгчийн дэвтэрт бичилт хийж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэх;	Нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийгдэн баталгаажуулсан байна.	Г
	6.Санхүүгийн тооцоолох программыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэн сар, улирал, жилийн баланс тайланг цаг хугацаанд нь гарган удирдлагадаа хянуулах;	Тайланг хугацаанд нь гарган удирдлагад танилцуулсан байна.	Г
	7.Харилцагч байгууллагуудтай улирал, хагас жил оны эцэст тооцоо нийлж, акт үйлдэн баримтаар баталгаажуулж дүнг тайлагнаж, өр авлагын	Харилцагч байгууллагуудтай улирал, хагас жил оны эцэст тооцоо нийлж, акт үйлдэн баримтаар	Г

	хуримтлалгүй байх нөхцөлийг хангах ажлыг хариуцан гүйцэтгэх;	баталгаажуулж дүнг тайлагнасан байна.	
3 дугаар зорилтын хүрээнд	1.Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн санхүүжилтийн хэмнэлт, хэтрэлт шалтгаан тайлбарын хамт сар бүр, улирал, хагас жил, бүтэн жилээр гаргаж тайлагнах;	Хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г
	2.Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого, зарлагын мэдээг тухай бүр холбогдох шийдвэрийн хамт мэдээллийг цахимд оруулах ажлыг хийж гүйцэтгэх;	Мэдээллийг байршуулсан байна.	Г
	3.Хагас, бүтэн жилээр гаргасан санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт, зөвлөмж түүний дагуу авч хэрэгжүүлэх ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлсэн тайлан зэрэг мэдээллийг оруулах ажлыг хийж гүйцэтгэх;	Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г
	4.Тоон чанарын үзүүлэлт, байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл зэрэг мэдээллийг бүтэн жилээр оруулах;	Тоон чанарын үзүүлэлт, байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл зэрэг мэдээллийг бүтэн жилээр оруулсан байна.	Г
	5.Төсвийн хөрөнгө мөнгө зарцуулах тушаал шийдвэрийг тухай бүр оруулах ажлыг хийж гүйцэтгэх.	Хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
Мэргэжил	- нягтлан бодох бүртгэл; - санхүү; - эдийн засаг.
Мэргэшил	
Туршлага	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх.

Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - албан үүргээ хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; - албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - ажилдаа бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт сайтай байх; - ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; - иргэнтэй хүндэтгэлтэй, соёлтой харилцах; - бусад.
	Бусад	- монгол хэлний ярианы болон бичгийн ур чадвартай байх; - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах ур чадвар сайтай, эмх цэгцтэй байх; - өөрийн мэдлэг, ур чадварыг бүрэн дайчлах, бусдын санал, бодлыг сонсох; - багаар ажиллах чадвартай байх; - англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын өргөн хэрэглээний программ болон тооцооллын программыг эзэмшсэн байх; - төрийн болон албаны нууцыг хадгалах; - илүү цагаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект
	1.Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, албан хаагч;

	2.Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга; 3.Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн холбогдох албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

Э. ..... Э.Ж.....

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20..... оны ..... дугаар сарын ..... -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Шийдвэрийн огноо: ...

Дугаар: .....

(тамга/тэмдэг)

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА ..... Ж.ЖАМБААЖАМЦ/

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20..20.. оны 5.. дугаар сарын 21 -ны өдөр

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын
2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн Б/127
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☑ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан.

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Санхүүгийн зохицуулах хороо	Захиргаа удирдлагын газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Санхүү, хөрөнгө оруулалтын албаны нярав	Мэргэжлийн албан хаагч, ТҮ-4
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Санхүүгийн зохицуулах хорооны эд аж ахуй, санхүүгийн үйлчилгээний туслах ажлыг гүйцэтгэн хэрэгжүүлэх.

Албан тушаалын зорилт:

1.Санхүүгийн зохицуулах хорооны аж ахуй, санхүүгийн туслах ажлыг гүйцэтгэн хэрэгжүүлэх.

2.Хорооны эд хөрөнгийн бүртгэлийг стандартын дагуу хөтөлж, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, тооллого тооцоог хариуцах, үндсэн хөрөнгө болон бараа материалын тайлангуудыг ангилалаар нь хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж тооцооны нягтлан бодогчид хянуулах.

3.Хорооны бараа материал болон хангамжийн бусад материалын тасралтгүй байдлыг хангах, ажиллагсдын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тайлагнах, жижиг мөнгөн сангийн бүртгэл тооцоог зохих хууль, дүрэм журмын дагуу хөтлөн, зарцуулалтын тайлан гаргах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Байр, үйлчилгээтэй холбоотой аж ахуйн асуудлыг цаг тухайд нь хийж гүйцэтгүүлэх, хяналт тавих;	Байр, үйлчилгээтэй холбоотой аж ахуйн асуудлыг цаг тухайд нь хийж гүйцэтгүүлсэн байна.	Г, Х
	2.Батлагдсан төсвийн дагуу худалдан авсан бараа материал, тоног төхөөрөмж, эд хогшил, үнэт цаас зэргийг хүлээн авахдаа тоо, ширхэг, чанар, бүрэн бүтэн байдал, холбогдох бичиг баримттай тохирч байгаа эсэхийг шалгаж шошго, паспорт, бусад баримт бичгийг хадгалах, тэмдэглэгээ хийх ажлыг хийж гүйцэтгэх;	Бараа материал бусад зүйлсийг хүлээн авахдаа чанар, бүрэн бүтэн байдлыг шалган холбогдох баримт бичигтэй тулгасан байна.	Г
	3.Хорооны үйл ажиллагаанд шаардагдах үндсэн хөрөнгө, техник, тоног төхөөрөмж, хангамжийн материалын судалгааг гаргах, зах зээлийн үнийг харьцуулсан судалгааны сан бүрдүүлэх ажлыг хийж гүйцэтгэх;	Холбогдох судалгааг гаргасан байна.	Г
	4.Үндсэн хөрөнгө, бараа материал, тоног төхөөрөмж, үнэт цаас зэргийг хүлээн авах, тавьж олгохдоо анхан шатны баримтад тавигдах шаардлага хангасан баримтыг	Үндсэн хөрөнгө, бараа материал, тоног төхөөрөмж, үнэт цаас зэргийг хүлээн авах, тавьж	Г

	үндэслэн орлого, зарлагын бүртгэл хөтөлж, сар бүрийн эцэст тайлан гаргаж, бодит үлдэгдэлтэй тулгалт хийж, тайланг тооцооны нягтлан бодогчоор баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэх;	олгохдоо анхан шатны баримтад тавигдах шаардлага хангасан баримтыг үндэслэн орлого, зарлагын бүртгэл хөтөлж, нягтлан бодогчоор баталгаажуулсан байна.	
	5.Өөрийн хариуцсан ажилтай холбоотой бичиг баримт болон санхүүгийн албаны бусад бичиг баримтыг Архивын зааврын дагуу бүрдүүлж архивд хүлээлгэн өгөх ажлыг хийж гүйцэтгэх;	Холбогдох баримт бичгийг архивд хүлээлгэн өгсөн байна.	Г
	6.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах;	Хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган программд бүртгэх;	Хорооны үндсэн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүрэн хяналт тавьж, стандартын дагуу бүртгэл хөтлөн хөрөнгө хөдлөлийн тайлан гаргасан байна.	Г
	2.Хорооны эд хөрөнгийн бодит нөөцөд тулгуурлан Ажлын алба, Хяналтын зөвлөлийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг хийж гүйцэтгэх;	Ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан байна.	Г
	3.Ажилтнуудын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан эзэмшигчийн карт хөтөлж, өөрчлөлтийг тухай бүр тусгаж, эд хариуцагчдаар гарын үсэг зуруулж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэх;	Хяналтын карт хөтөлж, өөрчлөлтийг тухай бүр бүртгэн эд хариуцагчид танилцуулсан байна.	Г
	4.Улирал бүр эд хөрөнгө эзэмшигч ажилтнуудын картын бүртгэлийг хөрөнгийн үлдэгдэлтэй тулган шалгаж, үндсэн хөрөнгийг төрөлжүүлэн кодчилох ажлыг хийж гүйцэтгэх;	Эд хөрөнгийг бүрэн кодчилсон байна.	Г

	5.Хорооны эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт төрөлжилтийг хариуцан, агуулахыг эмх цэгцтэй байлгаж хагас бүтэн жил, гэнэтийн тооллого хийхэд тоолж байгаа эд зүйлийг нэг бүрчлэн үзүүлж тоолуулан тооллогын үр дүнг бүртгэлд тусгах бүртгэлээр байвал зохих үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад биеэр оролцох ажлыг хийж гүйцэтгэх;	Хорооны эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт төрөлжилтийг хариуцан ажилласан байна.	Г
	6.Тээврийн хэрэгслүүдийн хувийн хэргийн баяжилт, бичилтийг хөтлөх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон жолоочийн тодорхойлолт, шилжүүлсэн эзэмшүүлсэн бүртгэл, тээврийн хэрэгслийн түлхүүр, багаж хэрэгслийг зохих журмын дагуу тогтмол бүртгэн, тулгалт хийж баталгаажуулах;	Тээврийн хэрэгслүүдийн хувийн хэргийг хариуцан ажилласан байна.	Г
	7.Тээврийн хэрэгсэл бүрд хийсэн урсгал засвар, запаас сэлбэг хаанаас хэрхэн сольсон, үйлчилгээ хийсэн тусгай тэмдэглэлийг хөтлөх, авто техникийн улсын үзлэг, оношилгоонд цаг хугацаанд нь хамруулах;	Төлөвлөгөөт ажлыг цаг хугацаанд нь зохион байгуулсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Бараа материал, жижиг мөнгөн сангийн орлого, зарлагын гүйлгээг анхан шатны баримтад тулгуурлан санхүүгийн программд үнэн зөв шивэх, Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлд санхүүгийн программ болон бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэхэд анхаарч ажиллах;	Бараа материаалын зарцуулалтын баримт, жижиг мөнгөн сангийн орлого зарлагын гүйлгээ болон санхүүгийн бусад анхан шатны баримтыг үндэслэн үнэн зөв тайлан гаргасан байна.	Г
	2.Жижиг мөнгөн сангийн орлого зарлагын гүйлгээг анхан шатны баримт, мөнгө олгохыг хүссэн өргөдөл зэрэг төлбөр гүйцэтгэх эрхийг олгосон албан ёсны шийдвэрт үндэслэн цохолт хийсэн баримтаар олгох ажлыг хийж гүйцэтгэх;	Албан ёсны баримтад үндэслэн асуудлыг шийдвэрлэсэн байна.	Г
	3.Бараа материал, тоног төхөөрөмж, үнэт цаас зэргийг хүлээн авах, тавьж олгохдоо анхан шатны баримтад тавигдах шаардлага хангасан баримтыг үндэслэн орлого, зарлагын бүртгэл хөтөлж, сар бүрийн эцэст тайлан гаргаж, бодит үлдэгдэлтэй	Аж ахуй, бараа материал, хөрөнгө болон бусад шаардлагатай зүйлсийн үнэ, чанарын баталгаат байдлыг ханган	Г

	тулгалт хийж, тайланг тооцооны нягтлан бодогчоор баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэх;	нийлүүлж, зарцуулалтыг хянан үр ашигтай байлгахад анхаарч ажилласан байна.	
	4.Ажилтнуудад хуваарийн дагуу олгогдож байгаа хангамжийн материалыг урьдчилан нөөцлөх, тасралтгүй байдлыг хангах.	Тасралтгүй байдлыг ханган ажилласан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	- нягтлан бодох бүртгэл; - санхүү; - бизнесийн удирдлага; - эдийн засаг; - математик, статистик; - нийгмийн шинжлэх ухаан; - төрийн удирдлага; - мэдээлэл харилцаа, холбооны технологи; - эрх зүй.		
Мэргэшил			
Туршлага	Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн анхан шатны бүртгэлийг тухай бүр хөтөлж, тайлан гаргах чадвартай байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - албан үүргээ хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; - албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх; - бусад.	
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - ажилдаа бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт сайтай байх; - ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; - иргэнтэй хүндэтгэлтэй, соёлтой харилцах; - бусад.	
	Бусад	- монгол хэлний ярианы болон бичгийн ур чадвартай байх; - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах ур чадвар сайтай, эмх цэгцтэй байх;	

		- өөрийн мэдлэг, ур чадварыг бүрэн дайчлах, бусдын санал, бодлыг сонсох; - багаар ажиллах чадвартай байх; - компьютерын өргөн хэрэглээний программ болон тооцооллын программыг эзэмшсэн байх; - төрийн болон албаны нууцыг хадгалах; - илүү цагаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект
	1.Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, албан хаагч; 2.Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга; 3.Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн холбогдох албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

..... /.....

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20..... оны ..... дугаар сарын ..... -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: .....

(тамга/тэмдэг)

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА ..... /Т.ЖАМБААЖАМЦ/

(Гарын үсэг) (Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)

20 20 оны 5 дугаар сарын 25 -ны өдөр

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын
2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн Б/127
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

○ [√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан.

○ [ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг батлагдсан огноо:

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
○ Санхүүгийн зохицуулах хороо	Захиргаа удирдлагын газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Бичиг хэргийн эрхлэгч	Мэргэжлийн албан хаагч, ТҮ-5
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

○ Албан хэрэг хөтлөлтийн ажлыг байгууллагын хэмжээнд "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-ын дагуу стандарт шаардлагад нийцүүлэн орчин үеийн мэдээллийн технологи нэвтрүүлэх, баримт бичгийн хөтлөлт, бүрдэл хяналтыг гүйцэтгэх замаар Хорооны удирдлагууд болон албан хаагчдад шуурхай үйлчилж, бичиг хэрэгт хүлээн авсан бичгийг ангилан төрөлжүүлэн илгээх, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих.

Албан тушаалын зорилт:

1.Байгууллагад шуудан, факс, иргэдээс ирсэн баримт бичгийг цаг тухайд нь хүлээн авах, ангилах, программд бүртгэх, хариу шаардсан албан бичигт бүртгэл хяналтын карт хөтлөх, удирдлагад танилцуулахаар шилжүүлэх.

2.Явуулах баримт бичгийг хүлээн авч, бүрдлийг шалган программд бүртгэх, дугаар өгөх, цаг тухайд нь дуггуйлж хаяглан илгээх.

3.Баримт бичгээр тавьсан асуудлын шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, үр дүнг удирдлагад мэдээлэх, шийдвэрлэх хугацаа хэтэрсэн баримт бичиг, өргөдөл гомдлын мэдээг тогтмол гаргах.

4.Бичиг хэргийн үйл ажиллагаанд үүсэж хөтлөгдсөн баримт бичгийг төрөлжүүлэн архивын баримт болгох.

5.Бичиг хэргийн эргэлтийн судалгаа, бусад тайлан мэдээг гаргах.

6.Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хууль, тогтоомж биелүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хороонд албан байгууллага, иргэдээс ирсэн албан бичиг, өргөдөл гомдлыг шалган хүлээн авч, ангилан программд бүртгэн цаг тухайд нь удирдлагад танилцуулахаар шилжүүлэх;	Ирсэн баримт бичгийг тухай бүр программд бүрэн бүртгэж холбогдох албан тушаалтан, нэгжүүдэд шилжүүлсэн байна.	Г
	2.Хорооны зохицуулалт хяналтад хамаарах асуудлаар ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэл хөтлөн цаг тухайд нь удирдлагад танилцуулах, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, үр дүнг удирдлагад мэдээлэх, шийдвэрлэх хугацаа хэтэрсэн баримт бичиг, өргөдөл гомдлын мэдээг тогтмол гаргах;	Хугацаа хэтэрсэн баримт бичиг, өргөдөл гомдлын мэдээг тогтмол гаргасан байна.	Г
	3.Ирсэн албан бичиг, өргөдөл гомдолд танилцуулах хуудас болон бүртгэл хяналтын карт нээн удирдлагад танилцуулах, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, үр дүнг удирдлагад мэдээлэх, шийдвэрлэх хугацаа	Ирсэн баримт бичиг, өргөдөл гомдолд танилцуулах хуудас болон хяналтын карт нээн удирдлагад танилцуулсан байна.	Г

	хэтэрсэн баримт бичиг, өргөдөл гомдлын мэдээг тогтмол гаргах;		
	4.Дээд газрын тогтоол шийдвэрийг хүлээн авч холбогдох ажилтанд шууд шилжүүлэн Хяналтын карт хөтлүүлэх;	Тогтоол шийдвэрт хяналтын карт хөтлөгдсөн байна.	Г
	5.Баримт бичгийг удирдлагын цохолтын дагуу холбогдох нэгж, албан тушаалтанд шилжүүлэх;	Баримт бичгийг холбогдох нэгжид шилжүүлэн ажилласан байна.	Г
	6.Программын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хариуцаж ажиллах;	Программын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хариуцаж ажилласан байна.	Г
	7.Программын сайжруулалт, өөрчлөлтийн талаар санал дүгнэлт гаргах;	Санал дүгнэлт хүргүүлсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Явуулах баримт бичгийг стандартын дагуу бүрдүүлсэн эсэхэд хяналт тавих;	Хяналт тавин ажилласан байна.	Х
	2.Явуулах албан бичгийг хүлээн авч бүрдлийг шалгах, программ бүртгэх, дугтуйлах, хаяглан илгээх;	Баримт бичгийг стандартын дагуу хаяглан илгээсэн байна.	Г
	3.Гадаад улсад явуулах бичгийн орчуулаг болон хавсралттай бичгийн хавсралтыг тухай баримт бичгийг боловсруулсан ажилтнаас авч, бүрдлийг хангах;	Баримт бичгийн бүрдэл хангагдсан байна.	Г
	4.Шуудангаар илгээсэн бичгийн бүртгэл хөтлөх;	Бүртгэл хөтлөн ажилласан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Хариу шаардсан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналтын картаар хяналт тавих;	Хариутай баримт бичиг хуулийн хугацаандаа бүрэн шийдвэрлэгдсэн байна.	Г, Х
	2.Шийдвэрлэх хугацаа хэтэрсэн баримт бичиг, өргөдөл гомдлын мэдээг 7 хоног тутам гаргаж удирдлагад мэдээлэх;	Мэдээллээр ханган ажилласан байна.	Г

	3.Хариутай бичигт хөтлөгдсөн карт болон программын бүртгэлд хаасан эсэхийг ажилтнуудаас шалгаж авах, шаардлага тавих;	Хяналтын карттай албан бичгүүд хаагдсан байна.	Г, Х
	4.Зохион байгуулалтын нэгжүүдийн албан хэрэг хөтлөлт, баримт бичигтэй ажиллах ажиллагаанд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангах;	Арга зүйгээр ханган ажилласан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Бичиг хэрэгт төвлөрөн хадгалагдаж буй баримт бичгийг дараа оны эхэнд ангилан төрөлжүүлж, хэрэг бүрдүүлэх;	Баримт бичгүүд бүрэн бүрдэлтэйгээр архивд шилжсэн байна.	Г
	2.Бүртгэлийн программд хадгалагдаж буй харилцсан бичгийн бүртгэлийг тусгай тээгчид хуулбарлан архивд шилжүүлэх;	Баримт бичгүүд бүрэн бүрдэлтэйгээр архивд шилжсэн байна.	Г
	3.Жагсаалт үйлдэн байгууллагын архивд шилжүүлэх;	Баримт бичгүүд бүрэн бүрдэлтэйгээр архивд шилжсэн байна.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	1.Баримт бичгийн эргэлтийн хэмжээг тогтооно;	Эрхэлсэн ажлын хүрээнд гардаг тоон мэдээллийг бүрэн гаргаж байгууллагын үйл ажиллагааны тайланд тусгагдсан байна.	Г
	2.Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу эргэлтийн мэдээг хуудсаар тооцон гаргана;	Бичиг хэргийн эргэлтийн мэдээг гаргасан байна.	Г
	3.Баримт бичгийн эргэлтийн мэдээ судалгааг гаргаж удирдлагад улирал бүр танилцуулна;	Удирдлагад танилцуулсан байна.	Г
6 дугаар зорилтын хүрээнд	1.Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомж,	Цаг үеийн шинж чанартай болон, эрхэлсэн асуудлын чиглэлээр удирдлагаас өгсөн үүрэг даалгавар	Г

	стандартыг баримталж ажиллах;	хугацаандаа, бүрэн биелж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна.	
	2.Хорооны удирдлага, Хорооны гишүүд, Хяналтын зөвлөлийн гишүүд, Ажлын алба, Газрын удирдлагыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хариуцсан чиглэлээрээ мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлж, үнэн зөв мэдээллээр хангах;	Удирдлагыг үнэн зөв мэдээллээр ханган ажилласан байна.	Г
	3.Хорооноос гарсан шийдвэр, Хорооны удирдлагаас өгөгдсөн үүрэг, даалгаврыг тухай бүр чанартай гүйцэтгэж тайлагнах;	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар хугацаандаа, бүрэн биелж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна.	Г
	4.Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшнийг үнэлж дүгнүүлэх;	Мэргэшлийн түвшнийг үнэлж, дүгнүүлсэн байна.	Г
	5.Эрхэлсэн ажилдаа идэвх санаачилгатай байж, өөрийн хариуцсан чиглэлээр мэргэшиж, холбогдох дүрэм, журмыг боловсронгуй болгох санал, санаачилга гаргах;	Манлайлалтай ажилласан байна.	Г
	6.Тухайн жилд хөтөлж дууссан хэргээ эмхэлж цэгцлэн байгууллагын архивд бүрэн бүрдэлтэйгээр хүлээлгэн өгөх.	Баримт бичгийг архивд бүрэн бүрдэлтэйгээр шилжүүлсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
Мэргэжил	- архив, бичиг хэргийн ажилтан; - нягтлан бодох бүртгэл; - эдийн засаг; - эрх зүй; - бизнесийн удирдлага.

Мэргэшил		
Туршлага		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - албан үүргээ хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; - албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - ажилдаа бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт сайтай байх; - ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; - иргэнтэй хүндэтгэлтэй, соёлтой харилцах; - бусад.
	Бусад	- монгол хэлний ярианы болон бичгийн ур чадвартай байх; - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах ур чадвар сайтай, эмх цэгцтэй байх; - архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын арга зүйгээр мэргэшсэн байх. - өөрийн мэдлэг, ур чадварыг бүрэн дайчлах, бусдын санал, бодлыг сонсох; - багаар ажиллах чадвартай байх; - англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын өргөн хэрэглээний программ болон тооцооллын программыг эзэмшсэн байх; - төрийн болон албаны нууцыг хадгалах; - илүү цагаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай байх.

IV АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Захиргаа удирдлагын газрын дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект
	1.Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн

	Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, албан хаагч; 2.Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга; 3.Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн холбогдох албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

..... /.....

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20..... оны ..... дугаар сарын ..... -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: .....

(тамга/тэмдэг)

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА ..... Т.ЖАМБААЖАМЦ/

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20..20..оны ..5.. дугаар сарын ..23.. -ны өдөр

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын
2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн Б/127
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☑ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан.

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг батлагдсан огноо:

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Санхүүгийн зохицуулах хороо	Захиргаа удирдлагын газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Архивын эрхлэгч	Мэргэжлийн албан хаагч, ТҮ-5
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хорооны архивыг Архивын тухай хууль, "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар" бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу эрхлэн явуулж, Хорооны архивын баримтын хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулах, төрийн байгууллагын нууцыг задруулахгүй, үрэгдүүлэхгүй байх, байгууллагын ашиг сонирхолд хор хохирол учрах явдлаас сэрэмжлэх.

Албан тушаалын зорилт:

1.Хорооны үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу заагдсан хугацаанд байгууллагын архивд бүрэн бүрдэлтэйгээр цэгцлүүлэн хүлээн авч, архивлах.

2.Архивын баримтын тоо бүртгэлийн материалыг үнэн зөв, бүрэн хөтлөх.

3.Архивын сан хөмрөгт хадгалагдаж буй баримтын хадгалалт хамгаалалтыг зааврын дагуу ханган ажиллах.

4.Архивын баримтаас дотоод, гадаад албан хэрэгцээнд баримтыг бүртгэл хөтлөн олгож, хүлээн авах, лавлагаа мэдээлэл олгох.

5.Хорооны удирдлагаас цаг үеийн шинж чанартай болон эрхэлсэн асуудлын чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлэх.

